



МОНГОЛЫН МЯНГАНЫ СОРИЛТЫН САН
MILLENNIUM CHALLENGE ACCOUNT - MONGOLIA

УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН АНХДУГААР ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛИЙН ХУРААНГУЙ

Огноо: 2018 оны 12 дугаар сарын 13
Хурал болсон газар: Гадаад харилцааны яам

ХЭЛЭЛЦСЭН АСУУДЛУУД

Монголын Мянганы сорилтын сан /Монголын МСС/-ийн Удирдах зөвлөлийн анхдугаар хурлаар дор дурдсан 5 асуудлыг хэлэлцэж, харгалзах шийдвэрийг батлав. Үүнд:

1. Монголын МСС-ийн дүрмийн төслийг хэлэлцэж, Удирдах зөвлөлийн гишүүдээс өгсөн саналуудыг тусган дүрмийн төслийг УЗ-ийн гишүүд санал нэгтгэйгээр батлав.
2. Удирдах Зөвлөлийн Нарийн бичгийн даргын үүрэг гүйцэтгэгчийг томилох тухай асуудлыг хэлэлцэж, Монголын Мянганы сорилтын сангийн Хуулийн Ерөнхий зөвлөх өрсөлдөөнт сонгон шалгаруулалтын үр дүнд сонгогдон томилогдож ажиллах хүртэл Удирдах Зөвлөлийн Нарийн бичгийн даргын үүрэг гүйцэтгэгчээр Монгол Улсын Засгийн газар, АНУ-ын МСК-ын хооронд байгуулах хоёр дахь Компакт гэрээ боловсруулах Үндэсний ажлын албаны Хуулийн зөвлөхийг томилохыг УЗ-ийн гишүүд санал нэгтгэйгээр батлав.
3. Монголын МСС-ийн Зохион байгуулалтын бүтцийг хэлэлцэж, Удирдах зөвлөлийн гишүүдээс гаргасан саналуудыг тусган санал нэгтгэйгээр батлав.
4. Компакт гэрээний талаар Үндэсний ажлын алба /ҮАА/-ны дарга танилцуулж, дэлгэрэнгүй мэдээлэл хийв.
5. Монголын МСС-ийн Гүйцэтгэх захирлын сонгон шалгаруулалтад тэнцсэн хүмүүстэй ярилцлага хийх багийн бүрэлдэхүүний талаар хэлэлцэв.

МОНГОЛЫН МЯНГАНЫ СОРИЛТЫН САН